

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/172/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: [maitsetsegt@audit.gov.mn](mailto:maitsetsegt@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: [gereltekhhburtgelaudit02@gmail.com](mailto:gereltekhhburtgelaudit02@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.2 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БСУГ	Боловсрол Соёл Урлагийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Угас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022-02-25 № 01/160  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ О.ПҮРЭВДУЛАМ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 ОЧ ДАЛБАН БСН16 19070508

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>31,596,538.58</u></b>	<b><u>37,737,288.58</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>31,596,538.58</b>	<b>37,737,288.58</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>31,596,538.58</b>	<b>37,737,288.58</b>
35410	Бичиг хэргийн материал	840,850.00	1,472,650.00
35420	Аж ахуйн материал	30,755,688.58	35,890,838.58
35460	Хүнсний материал		373,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>337,398,778.95</u></b>	<b><u>423,520,424.96</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>337,398,778.95</b>	<b>423,520,424.96</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>332,032,778.95</b>	<b>418,154,424.96</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	307,962,662.62	391,562,662.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,745,042.76)	(27,150,127.80)
39205	Машин тоног төхөөрөмж	38,452,554.36	54,306,554.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,155,022.55)	(26,169,187.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,211,083.85	54,821,083.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,587,956.71)	(29,838,860.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,922,000.00	1,922,000.00
39217	Ном	(1,027,499.86)	(1,299,699.82)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,366,000.00</b>	<b>5,366,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	5,366,000.00	5,366,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>368,995,317.53</u></b>	<b><u>461,257,713.54</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>368,995,317.53</u></b>	<b><u>461,257,713.54</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>368,995,317.53</b>	<b>461,257,713.54</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	375,255,248.95	375,255,248.95
51101	Өмч: - төрийн	375,255,248.95	375,255,248.95
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(7,617,856.20)</b>	<b>84,644,539.81</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(7,617,856.20)	(7,617,856.20)
51220	Тайлант үеийн үр дүн	-	92,262,396.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,357,924.78	1,357,924.78
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>368,995,317.53</u></b>	<b><u>461,257,713.54</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>403,258,783.28</b>	<b>435,161,050.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,231,183.28</b>	<b>109,112,750.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>15,231,183.28</b>	<b>109,112,750.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,231,183.28	109,112,750.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,231,183.28	109,112,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>65,307,000.00</b>	<b>30,723,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>29,344,600.00</b>	<b>30,723,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,344,600.00	30,723,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,720,600.00	295,324,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,962,400.00</b>	<b>-</b>

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,962,400.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>416,074,884.43</b>	<b>342,898,653.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>416,074,884.43</b>	<b>342,898,653.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>307,177,183.19</b>	<b>305,554,083.61</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>210,016,978.76</b>	<b>216,188,850.62</b>
210101	Үндсэн цалин	136,206,439.16	136,663,104.53
210102	Нэмэгдэл	50,180,202.60	55,130,388.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,298,000.00	6,095,999.00
210104	Урамшуулал	17,332,337.00	18,299,359.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,400,241.00</b>	<b>28,349,739.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,359,551.00	20,132,453.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,029,704.87	2,162,397.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,687,577.10	1,687,928.20
210204	Ажилгүйдлийн даатгал	425,537.65	412,659.23
210205	Эрүүл мэндийн даатгал	3,897,870.38	3,954,300.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,403,159.00</b>	<b>24,402,760.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,197,091.00	1,817,160.00
210302	Түлш, халаалт	20,680,568.00	22,060,100.00
210303	Цэвэр, бохир ус	525,500.00	525,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,559,273.72</b>	<b>914,250.00</b>
210401	Бичиг хэрэг	80,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	159,250.00	199,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	62,750.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	-	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	270,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	770,900.00	115,000.00
210408	Бараа материал акталсны зардал	8,486,373.72	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,907,650.00</b>	<b>12,343,530.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,000.00	65,000.00
210502	Хоол, хүнс	15,533,650.00	11,828,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	342,000.00	450,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>470,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	470,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	80,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>720,000.00</b>	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,619,880.71</b>	<b>22,854,953.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,545,000.00	1,361,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	810,270.00	907,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,264,610.71	20,586,353.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>108,897,701.24</b>	<b>37,344,570.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,962,400.00</b>	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,376,200.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>69,493,860.24</b>	<b>31,523,530.38</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,493,860.24	31,523,530.38
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,441,441.00</b>	<b>5,821,040.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,441,441.00	5,821,040.00

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(12,816,101.15)</u>	<u>92,262,396.01</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(12,816,101.15)</u></b>	<b><u>92,262,396.01</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	375,255,248.95	1,385,813.20	5,170,356.53	381,811,418.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,255,248.95	1,385,813.20	5,170,356.53	381,811,418.68
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,816,101.15)	(12,816,101.15)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	375,255,248.95	1,357,924.78	(7,617,856.20)	368,995,317.53
D01	2020 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	375,255,248.95	1,357,924.78	(7,617,856.20)	368,995,317.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,255,248.95	1,357,924.78	(7,617,856.20)	368,995,317.53
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	92,262,396.01	92,262,396.01
D09	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	375,255,248.95	1,357,924.78	84,644,539.81	461,257,713.54

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>388,027,600.00</u></b>	<b><u>326,048,300.00</u></b>	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>388,027,600.00</b>	<b>326,048,300.00</b>	
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>29,344,600.00</b>	<b>30,723,800.00</b>	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,344,600.00	30,723,800.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	322,720,600.00	295,324,500.00	
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,962,400.00</b>	<b>-</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,962,400.00	-	
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>388,027,600.00</u></b>	<b><u>324,998,300.00</u></b>	
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>388,027,600.00</b>	<b>324,998,300.00</b>	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>279,129,898.76</b>	<b>287,653,729.62</b>	
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>210,016,976.81</b>	<b>216,188,850.62</b>	
210101	Үндсэн цалин	136,206,437.21	136,663,104.53	
210102	Нэмэгдэл	50,180,202.60	55,130,388.09	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,298,000.00	6,095,999.00	
210104	Урамшуулал	17,332,337.00	18,299,359.00	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,400,242.95</b>	<b>28,349,739.00</b>	
210201	Тэтгэврийн даатгал	18,359,551.00	20,132,453.85	
210202	Тэтгэмжийн даатгал	2,029,704.87	2,162,397.24	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,687,577.10	1,687,928.20	
210204	Ажилгүйдлийн даатгал	425,537.65	412,659.23	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,897,872.33	3,954,300.48	

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,403,159.00</b>	<b>24,402,760.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,197,091.00	1,817,160.00
210302	Түлш, халаалт	20,680,568.00	22,060,100.00
210303	Цэвэр, бохир ус	525,500.00	525,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,134,700.00</b>	<b>3,001,050.00</b>
210401	Бичиг хэрэг	80,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	159,250.00	199,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	62,750.00	200,000.00
210404	Ном, хэвлэл	61,800.00	61,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	770,900.00	2,140,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,263,550.00</b>	<b>12,767,330.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,000.00	65,000.00
210502	Хоол, хүнс	11,781,550.00	12,202,330.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	80,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>720,000.00</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	720,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,611,270.00</b>	<b>2,444,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,801,000.00	1,537,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	810,270.00	907,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>108,897,701.24</b>	<b>37,344,570.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,962,400.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,376,200.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,200.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>69,493,860.24</b>	<b>31,523,530.38</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,493,860.24	31,523,530.38
213304	Хөрөнгийн	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,441,441.00</b>	<b>5,821,040.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,441,441.00	5,821,040.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>≡</b>	<b><u>1,050,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>1,050,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>1,050,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>1,050,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	1,050,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>≡</b>	<b><u>(1,050,000.00)</u></b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант оны	Зөрүү	Хувь
--	----------	-------------	-------	------

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>326,048,300.00</b>	<b>288,703,729.62</b>	<b>37,344,570.38</b>	<b>88.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>326,048,300.00</b>	<b>288,703,729.62</b>	<b>37,344,570.38</b>	<b>88.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>326,048,300.00</b>	<b>288,703,729.62</b>	<b>37,344,570.38</b>	<b>88.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>226,285,000.00</b>	<b>216,188,850.62</b>	<b>10,096,149.38</b>	<b>95.54</b>
210101	Үндсэн цалин	138,105,700.00	136,663,104.53	1,442,595.47	98.96
210102	Нэмэгдэл	57,495,900.00	55,130,388.09	2,365,511.91	95.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,040,000.00	6,095,999.00	944,001.00	86.59
210104	Урамшуулал	23,643,400.00	18,299,359.00	5,344,041.00	<b>77.40</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,548,400.00</b>	<b>28,349,739.00</b>	<b>2,198,661.00</b>	<b>92.80</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,497,100.00	20,132,453.85	1,364,646.15	93.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,262,900.00	2,162,397.24	100,502.76	95.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,810,300.00	1,687,928.20	122,371.80	93.24
210204	Ажилгүйдлийн даатгал	452,600.00	412,659.23	39,940.77	91.18
210205	Эрүүл мэндийн даатгал	4,525,500.00	3,954,300.48	571,199.52	87.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,223,800.00</b>	<b>24,402,760.00</b>	<b>5,821,040.00</b>	<b>80.74</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,637,900.00	1,817,160.00	5,820,740.00	23.79
210302	Түлш, халаалт	22,060,400.00	22,060,100.00	300.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	525,500.00	525,500.00	-	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,051,800.00</b>	<b>3,051,050.00</b>	<b>750.00</b>	<b>99.98</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	199,250.00	750.00	99.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	200,000.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	61,800.00	61,800.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	300,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,190,000.00	2,190,000.00	-	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,895,300.00</b>	<b>13,767,330.00</b>	<b>19,127,970.00</b>	<b>41.85</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,000.00	65,000.00	-	<b>100.00</b>
210502	Хоол, хүнс	31,330,300.00	12,202,330.00	<b>19,127,970.00</b>	<b>38.95</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	-	<b>100.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	-	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>100,000.00</b>	-	<b>100,000.00</b>	-

210702	Дотоод албан томилполт	100,000.00		<b>100,000.00</b>	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,444,000.00	2,444,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,537,000.00	1,537,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	907,000.00	907,000.00	-	100.00
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>326,048,300.00</b>	<b>326,048,300.00</b>	-	100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>326,048,300.00</b>	<b>326,048,300.00</b>	-	<b>100.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>326,048,300.00</b>	<b>326,048,300.00</b>	-	<b>100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	30,723,800.00	30,723,800.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	295,324,500.00	295,324,500.00	-	<b>100.00</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох
- Хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох
- Хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах
- Хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 8,321.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,241.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	31,596.5	37,737.3	6,140.8
Үндсэн хөрөнгө	337,398.8	423,520.4	86,121.6
Нийт хөрөнгө	<b>368,995.3</b>	<b>461,257.7</b>	<b>92,262.4</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	368,995.3	461,257.7	(15,646.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	368,995.3	461,257.7	(15,646.3)

Бараа материалын дансны үлдэгдэл 37,737.3 мянган төгрөг болж, 6,140.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан 17,908.9 мянган төгрөгийн бараа материалаар, хандиваар хүлээн авсан 4,068.7 мянган төгрөгийн материалаар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 423,520.4 мянган төгрөг болж, 86,121.6 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар авсан 83,600.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 14,804.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,610.0 мянган төгрөгийн тавилгаар нэмэгджээ. Үндсэн хөрөнгө данс нь тайлант оны элэгдлийн зардал 19,942.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 435,161.0 мянган төгрөг болж өмнөх оноос 31,902.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд материаллаг дүнтэй өөрчлөлт орсон данс нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого данс байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 326,048.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 326,048.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 326,048.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 326,048.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 326,048.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 326,048.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 288,703.7 мянган төгрөгийг зарцуулж, 37,344.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар

чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 423,520.4 мянган төгрөг болж, 86,121.6 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар авсан 83,600.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 14,804.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,610.0 мянган төгрөгийн тавилгаар нэмэгджээ. Үндсэн хөрөнгө данс нь тайлант оны элэгдлийн зардал 19,942.3 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Мөнгөн морьт сумын хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 439,069.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 295,454.7 мянган төгрөгийн 11 мэдээллийг огт байршуулаагүй, 37,344.6 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн данстай холбоотой 1 зөвлөмж байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	485,882.1	1	485,882.1	-	-	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>485,882.1</b>	<b>1</b>	<b>485,882.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>100</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 333,849.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,050.0 мянган алдаа зөрчлийг залруулж, 332,799.3 мянган төгрөгийн шилэн данстай холбоотой зөвлөмж болон үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалтын зардлын дүнд худалдан авсан 1,050.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайлагнаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 6.9-д “Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зарлага хэсэгт „, үндсэн хөрөнгө худалдан авах, олж бэлтгэхэд болон капиталжих их засварт зарцуулсан мөнгөн зардлыг харуулна”, санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 298 ширхэг 20,995.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, санхүүгийн тайлангийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

#### 2. Шилэн данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Төв аймгийн Мөнгөн морьт сумын хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд нийт 439,069.9 мянган төгрөгийн 22 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагч ил тод байршуулахаас 295,454.7 мянган төгрөгийн 11 мэдээллийг огт байршуулаагүй, 37,344.6 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн

дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалт дүнд тайлагнаагүй	1	1,050.0	1	1,050.0						
2	Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна									1	-
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>1,050.0</b>	<b>1</b>	<b>1,050.0</b>	-	-	-	-	<b>1</b>	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	332,799.3							1	332,799.3
<b>Дүн</b>		-	-	-	-	-	-	-	-	1	332,799.3
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>333,849.3</b>	<b>1</b>	<b>1,050.0</b>	-	-	-	-	<b>2</b>	<b>332,799.3</b>